



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/187

Улаанбаатар хот

Г Бүтэц, орон тоо батлах тухай 7

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.19 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн бүтэц, орон тоог нэгээс хорин гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Бүтэц, орон тоо, албан тушаалын нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахад ерөнхий удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, батлуулан мөрдөж ажиллахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан орон тоог баримтлан Төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон тоо, төсвийг үр ашигтай зарцуулж ажиллахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан төрийн албан хаагчийн албан тушаал, нийгмийн баталгааг бууруулахгүй байх, ажлын байран дээр мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Бүтэц, орон тоо батлах тухай" А/99 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0513

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2024 оны 03 дугаар сарын 00-ны өдрийн  
01/07.... дугаар тушаалын 6 дугаар хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Дарга	T3-4	1
2	Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
3	Бага боловсрол хариуцсан ахлах арга зүйч /цахим сургалт/	T3-7	1
4	Байгалийн ухааны боловсрол хариуцсан ахлах арга зүйч /цахим сургалт/	T3-7	1
5	Нийгмийн ухааны боловсрол хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
6	Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
7	Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
8	Сургалтын орчин, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
9	Статистикийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
10	Төсвийн төлөвлөлт, зохицуулалт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
11	Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах арга зүйч	T3-7	1
12	Боловсролын хяналтын улсын байцаагч	T3-7	1
13	Нягтлан бодогч	TY-8	1
14	Архив, бичиг хэргийн эрхлэгч	TY-5	1
15	Нярав	TY-4	1
16	Жолооч	TY-3	1
17	Үйлчлэгч	TY-1	1
НИЙТ			17